




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2019 I-III



**ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 2019 ОНЫ
ЭХНИЙ УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

2019 он

АГУУЛГА

Оршил	4
Нэг. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ	6
1.1. ДНБ, оны үнээр.....	6
1.2. Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ.....	7
1.3. Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл (салбарын улирлын мэдээгээр)	8
Хоёр. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ	15
2.1 ДНБ, оны үнээр.....	15
2.2 ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр.....	6
Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	6
Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр.....	7
Хүснэгт 4. Бойжуулсан төл, зүй бусаар хорогдсон том мал	8
Хүснэгт 5. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	8
Хүснэгт 6. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	8
Хүснэгт 7. Уул уурхайн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт.....	9
Хүснэгт 8. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	9
Хүснэгт 9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр	10
Хүснэгт 10. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр	11
Хүснэгт 11. Дотоод, гадаад худалдааны борлуулалтын хэмжээ.....	11
Хүснэгт 12. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт	12
Хүснэгт 13. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт.....	12
Хүснэгт 14. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр	13
Хүснэгт 15. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацааны эцэст.....	13
Хүснэгт 17. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр	15
Хүснэгт 18. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	16
Хүснэгт 19. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-д салбаруудын оролцоо, өсөлт, бүүралт	6
Зураг 2. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар	7
Зураг 3. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий өсөлт, хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)	7
Зураг 4. Барилга угсралт, их засварын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, импорт	10
Зураг 5. Дотоод, гадаад худалдааны борлуулалтын хэмжээ	11
Зураг 6. Тээврийн салбарын орлого, тэрбум төгрөгөөр	12
Зураг 7. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, тэрбум төгрөгөөр	14
Зураг 8. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар.....	15

Товчилсон үг

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮ	Нийт үйлдвэрлэл
НӨ	Нэмэгдэл өртөг
ӨҮАББ	Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

Тайлбар

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

* Урьдчилсан гүйцэтгэл

Оршил

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тайлант хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспорт (экспорт, импортын зөрүү)-ын нийлбэрээр тооцохыг эцсийн ашиглалтын; ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар (үйлдвэрлэл, импортын татвар, татаасын зөрүү), үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ийг улирлаар үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар тооцно. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ нь шинээр бий болсон нэмэгдэл өртөг аль салбарт бий болсныг харуулах бол эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь үйлдвэрлэгчдийн бий болгосон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашигласныг харуулна. Энэ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.


Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлно. Эдийн засгийн орчин, салбарын бүтцэд гарах өөрчлөлт нь суурь оныг тодорхой давтамжтай өөрчлөх үндэслэл болдог.

Уг танилцуулгад ДНБ-ий үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын аргаар тооцсон үр дүн болон ДНБ-тэй холбогдох макро-эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдийг тусгасан.



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)

Монгол Улсын
эдийн засаг 2019
оны эхний улиралд



ДНБ-ий өсөлт, хувиар



ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ-ИЙ БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



*- Уул уурхай, олборлолтын салбар ороогүй



ЭХ ҮҮСВЭР:
Монгол Улсын Үндэсний
статистикийн хороо

Эдийн засаг 2019 оны эхний улиралд 8.6 хувиар өслөө

Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 127.7 (8.0%) тэрбум төгрөг, аж үйлдвэр, барилгын салбарынх 124.9 (11.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Нэг. Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ

1.1. ДНБ, оны үнээр

ДНБ, оны үнээр 2019 оны эхний улиралд 7.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 (17.0%) их наяд төгрөгөөр өслөө.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

	2016	2017 ¹	2018*	2019*	<u>2017¹ I-III</u>	<u>2018* I-III</u>	<u>2019* I-III</u>
	I-III	I-III	I-III	I-III	2016 I-III	2017 ¹ I-III	2018* I-III
	тэрбум төгрөг				хувь		
ДНБ	4 738.1	5 831.5	6 783.8	7 936.7	123.1	116.3	117.0
Хөдөө аж ахуй	181.1	186.6	223.4	239.6	103.0	119.7	107.2
Аж үйлдвэр, барилга	1 574.4	2 360.6	2 805.0	3 292.1	149.9	118.8	117.4
Уул уурхай, олборлолт	933.0	1 614.5	1 920.6	2 333.8	173.0	119.0	121.5
Үйлчилгээ	2 532.1	2 740.3	2 991.2	3 545.3	108.2	109.2	118.5
Бүтээгдэхүүний цэвэр татвар	450.5	544.0	764.1	859.7	120.7	140.5	112.5

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны эхний улиралд 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.3 (8.6%) их наяд төгрөгөөр өслөө.

Хүснэгт 2. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2016 ¹	2017 ¹	2018*	2019*	<u>2017¹ I-III</u>	<u>2018* I-III</u>	<u>2019* I-III</u>
	I-III	I-III	I-III	I-III	2016 I-III	2017 ¹ I-III	2018* I-III
	тэрбум төгрөг				хувь		
ДНБ	2 934.3	3 058.4	3 247.7	3 527.6	104.2	106.2	108.6
Хөдөө аж ахуй	122.2	126.9	131.6	134.4	103.9	103.7	102.1
Аж үйлдвэр, барилга	1 084.6	1 064.8	1 118.1	1 243.0	98.2	105.0	111.2
Уул уурхай, олборлолт	813.6	769.6	792.7	907.2	94.6	103.0	114.4
Үйлчилгээ	1 429.3	1 513.6	1 587.3	1 715.0	105.9	104.9	108.0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	298.2	353.0	410.7	435.2	118.4	116.3	106.0

Зураг 1. ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-д салбаруудын оролцоо, өсөлт, бууралт



ДНБ-ий 8.6 хувийн өсөлтийн 3.8 пунктийг аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг (НӨ), 1.6 пунктийг бөөний, жижиглэн худалдааны салбарын НӨ, 0.6 пунктийг тээвэр, мэдээлэл, холбооны салбарын НӨ, 1.8 пунктийг үйлчилгээний бусад салбарын НӨ-ийн өсөлтийг тус тус хангасан байна.


Хүснэгт 3. ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо, пунктээр

	2017 ¹				2018*				2019*
	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III	I-VI	I-IX	I-XII	I-III
ДНБ-ий өсөлт, %	4.2	5.4	6.0	5.3	6.2	6.4	6.5	6.9	8.6
Хөдөө аж ахуй	0.2	0.6	0.6	0.2	0.2	0.2	0.3	0.6	0.1
Уул уурхай, олборлолт	-1.5	-1.2	-0.2	-1.4	0.8	0.3	0.1	1.1	3.5
Боловсруулах	1.1	1.0	1.1	1.1	0.5	0.8	0.6	1.0	0.2
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.1	0.1	0.1	0.1	0.3	0.2	0.2	0.1	0.1
Барилга	-0.4	-0.3	-0.2	0.3	0.2	-0.1	-0.2	-0.2	0.1
Бөөний, жижиглэн худалдаа	1.6	1.1	0.9	0.9	0.8	1.0	0.7	0.4	1.6
Тээвэр, мэдээлэл, холбоо	1.0	1.1	1.0	1.3	0.1	0.3	0.8	0.6	0.6
Үйлчилгээний бусад	0.2	0.7	0.7	1.1	1.5	1.2	1.4	1.3	1.8
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.9	2.2	1.9	1.6	1.9	2.5	2.5	2.0	0.8

ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцоо

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг уул уурхайн болон уул уурхайн бус¹ гэж ангилан ДНБ-ий гүйцэтгэлийг харьцуулбал, уул уурхайн салбар 2016 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 15.6 хувь, 2018 оны эхний улиралд 3.0 хувиар өсөж байсан бол 2017 оны эхний улиралд -5.4 хувь хувиар буурч байсан. Эдийн засгийн өсөлт 2019 оны эхний улиралд 8.6 хувиар өссөн бөгөөд үүнээс уул уурхайн салбарт 14.4 хувь, уул уурхайн бус салбарт 6.7 хувийн өсөлттэй гарсан байна. Уул уурхайн салбарын энэ өсөлтөд нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал (чанарын өөрчлөлтийг тусгаснаар), цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүний олборлолт өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 2. ДНБ-ий өсөлт, уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, хувиар



1.2. Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ

Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны эхний улиралд өмнөх улирлаас 0.1 хувиар өслөө.

Зураг 3. ДНБ (улирлын нөлөөллийг арилгасан)-ий өсөлт, хувиар (2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх улирлаас)



¹ Уул уурхайн бус салбар гэж уул уурхай, олборлолтын салбараас бусад салбарыг ойлгоно.

1.3. Эдийн засагт голлох салбаруудын үйлдвэрлэл (салбарын улирлын мэдээллээр)

Хөдөө аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 0.1 пунктийг бүрдүүлж байна.

Улсын хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны хээлтэгч малын 6.2 сая (20.8%) нь 2019 оны эхний улиралд төллөсөн байна. Гарсан төлийн 97.6 хувь буюу 6.0 сая төл бойжиж, өмнөх оны мөн үеэс 1.8 (42.6%) саяар өссөн байна. Зүй бусаар хорогдсон том мал 2019 оны эхний улиралд улсын хэмжээнд 0.3 сая болж, өмнөх оны мөн үеэс 0.8 (-73.6%) саяар буурав.

Хүснэгт 4. Бойжуулсан төл, зүй бусаар хорогдсон том мал

Үзүүлэлт	2016	2017	2018	2018 I-III	2019 I-III	<u>2019 I-III</u> <u>2018 I-III</u>
	мянган толгой					хувиар
Малын тоо, оны эхэнд	55 979.7	61 549.2	66 219.0
Бойжуулсан төл	19 721.7	22 642.0	19 403.3	4 242.4	6 048.0	142.6
Том малын зүй бус хорогдол	1 452.1	888.0	2 635.4	1 116.9	295.0	26.4
Хүнсэнд бэлтгэсэн мал	12 700.0	14 105.8	16 526.7
Малын тоо, оны эцэст	61 549.2	66 219.0	66 460.2

Аж үйлдвэр, барилгын салбар

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 3.8 пунктийг бүрдүүлж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл (оны үнээр) 2019 оны эхний улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 3.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 (17.5%) их наяд төгрөгөөр өслөө.

Хүснэгт 5. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Аж үйлдвэрийн салбар	2016	2017	2018	2019*	<u>2017 I-III</u> <u>2016 I-III</u>	<u>2018 I-III</u> <u>2017 I-III</u>	<u>2019* I-III</u> <u>2018 I-III</u>
	тэрбум төгрөг				хувь		
Нийт дүн	1 805.9	2 688.9	3 267.6	3 839.9	148.9	121.5	117.5
Уул уурхай, олборлох	1 200.5	1 962.2	2 334.6	2 832.9	163.4	119.0	121.3
Боловсруулах	346.8	464.2	627.1	672.8	133.9	135.1	107.3
Цахилгаан, дулаан, ус хангамж	258.7	262.5	306.0	334.1	101.5	116.6	109.2

Уул уурхай, олборлох салбар

Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний улиралд 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 (21.3%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Үзүүлэлт	2016	2017	2018	2019*	Бүтэц		
	I-III	I-III	I-III	I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III
тэрбум төгрөг				хувь			
Нийт дүн	1 200.5	1 962.2	2 334.6	2 832.9	100.0	100.0	100.0
Нүүрс олборлолт	166.1	570.2	778.8	1 284.2	29.1	33.4	45.3
Газрын тос олборлолт	153.2	228.3	260.5	238.1	11.6	11.2	8.4
Металлын хүдэр олборлолт	874.9	1 141.2	1 269.3	1 286.5	58.2	54.4	45.4
Бусад ашигт малтмал	6.3	22.4	25.9	24.2	1.1	1.1	0.9

Уул уурхай, олборлох салбарт дэд салбаруудын эзлэх хувийг харьцуулбал, нүүрс олборлох салбарынх өсөж, харин металлын хүдэр олборлох салбарынх бүүрчээ. Экспортод гаргаж буй бүтээгдэхүүний ихэнх хувийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн эзэлдэг. Нүүрс олборлолтын хэмжээ 2019 оны эхний улиралд 12.9 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (15.1%) сая тонноор, нүүрсний экспортын хэмжээ 7.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (15.3%) мянган тонноор өссөн байна.

Хүснэгт 7. Уул уурхайн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт

	2018 I-III		2019* I-III		2019* I-III 2018 I-III	
	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт	Олборлолт	Экспорт
Нүүрс, мян.т	11 197.6	6 769.0	12 887.6	7 804.2	115.1	115.3
Газрын тос, мян.бар	1 745.8	1 631.2	1 671.1	1 620.6	95.7	99.4
Молибдений баяжмал, тн	1 317.6	1 406.6	1 223.1	1 395.8	92.8	99.2
Алт, кг	1 870.8	2 949.9	1 307.6	4 665.2	69.9	158.1
Төмрийн хүдэр, баяжмал, мян.т	1 944.7	1 440.9	1 998.7	2 071.8	102.8	143.8
Зэсийн баяжмал, мян.т	330.1	337.7	353.2	361.4	107.0	107.0
Хайлуур жонш, баяжмал, мян.т	41.4	78.3	28.5	110.6	68.8	141.3
Цайрын хүдэр баяжмал, мян.т	23.4	32.9	24.0	44.0	102.4	133.7

➤ *Боловсруулах салбар*

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний улиралд 672.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 45.8 (7.3%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд шар айраг, вакуум цонх, хаалга, ноолууран сүлжмэл эдлэл, банш, бууз, самнасан ноолуур, барилгын модон хаалга, цонх зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.0-97.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2016	2017	2018	2019*	2018 I-III	2019 *I-III
	I-III	I-III	I-III	I-III	2017 I-III	2018 I-III
	тэрбум төгрөг				хувь	
Нийт дүн	346.8	464.2	627.1	672.8	135.1	107.3
Хүнс, ундаа үйлдвэрлэл	219.2	258.2	341.1	335.8	132.1	98.4
Малын мах, мян.т	1.4	2.1	1.2	2.5	57.8	2.0 ¹
Гурил, мян.т	38.0	56.9	62.5	50.0	109.8	80.0
Спирт, сая л	2.4	2.5	2.7	2.6	104.2	96.3
Архи, дарс, сая л	5.3	6.1	7.7	6.6	125.2	86.5
Шар айраг, сая л	15.1	17.7	19.1	19.5	108.3	102.0
Тамхи үйлдвэрлэл	-	3.1	5.4	3.2	172.9	59.4
Тамхи, мян.блок	-	652.3	957.9	784.9	146.9	81.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	45.2	56.5	73.0	104.1	129.3	142.5
Хивс, мян.м2	84.5	100.2	95.8	71.5	95.6	74.7
Самнасан ноолуур, т	71.2	51.2	53.2	99.8	103.9	187.6
Эсгий, мян.м	8.1	15.0	18.2	16.9	121.3	92.9
Хувцас үйлдвэрлэл	4.9	9.0	9.7	8.5	107.4	87.4
Нэхий дээл, мян.ш	1 818.0	4 799.0	1 943.0	2 978.0	40.5	153.3
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гүтал	3.4	4.5	5.0	4.4	111.1	87.1
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	2.7	3.2	4.8	3.7	149.4	75.9
Зүсмэл материал, мян.м3	2.4	2.5	3.8	3.8	150.3	98.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2.0	3.4	4.5	6.2	133.8	137.8
Нийтлэх, хэвлэх үйл ажиллагаа	5.9	5.9	7.5	7.0	126.7	93.3

Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	27.4	62.0	85.4	78.9	137.7	92.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.0	16.4	19.8	37.5	120.2	189.6
Резин, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.6	4.3	4.7	5.6	108.0	118.9
Вакуум цонх, хаалга, мян.м2	3.4	4.3	4.5	5.2	104.4	117.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	6.3	8.7	21.3	25.4	2.5 ¹	119.5
Цемент, мян.т	10.8	23.0	70.4	121.6	3.0 ¹	172.7
Шохой, мян.т	4.0	15.0	5.4	17.3	36.0	3.2 ¹
Төмрийн үйлдвэрлэл	14.1	25.6	41.1	47.5	160.1	115.7
Металл бэлдэц, мян.т	0.1	5.6	8.0	7.8	142.9	97.6
Металл цувимал, мян.т	-	2.8	7.8	7.6	2.8 ¹	97.4
Катодын зэс, мян.т	3.8	3.7	3.6	3.3	95.7	92.0
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.4	0.5	0.6	1.2	123.7	202.2
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	0.1	-	0.2	0.7	-	4.0 ¹
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	0.1	0.1	0.1	0.1	192.0	48.9
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	0.2	0.4	0.3	0.0	83.7	11.9
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	0.5	0.8	0.9	0.9	124.2	92.0
Тавилга үйлдвэрлэл, бусад	1.8	1.5	1.5	2.2	99.3	141.2

¹ – дахин их

Барилгын салбар

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ (оны үнээр) 2019 оны эхний улиралд 391.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 55.1 (16.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр

Барилгын төрөл	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III	<u>2018 I-III</u> 2017 I-III	<u>2019* I-III</u> 2018 I-III
	тэрбум төгрөг				хувь	
Барилга угсралт, их засварын ажил	229.4	233.2	335.9	391.1	144.1	116.4
Орон сууцны барилга	79.5	75.3	49.0	95.7	65.0	195.2
Орон сууцны бус барилга	90.3	121.1	200.3	277.6	165.4	138.6
Инженерийн барилга, байгууламж	57.5	34.8	80.3	14.6	230.5	18.2
Их засварын ажил	2.0	2.0	6.4	3.2	326.1	50.5

Барилга угсралт, их засварын ажил 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өслөө. Барилга угсралт, их засварын ажлын гол түүхий эд болох барилгын материалын үйлдвэрлэл (оны үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 17.0 хувь, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 6.9 хувиар түс түс нэмэгдсэн байна.

Зураг 4. Барилга угсралт, их засварын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, импорт



➤ *Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбар*

Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний улиралд 334.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.2 (9.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Цахилгаан эрчим хүч, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, оны үнээр

Дэд салбар	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III	<u>2018 I-III</u> 2017 I-III	<u>2019* I-III</u> 2018 I-III
	тэрбум төгрөг				хувь	
Нийт дүн	258.7	262.5	306.0	334.1	116.6	109.2
Цахилгаан, дулаан, уур	240.3	243.2	285.3	312.1	117.3	109.4
Ус ариутгал, усан хангамж	18.4	19.3	20.7	22.1	107.4	106.5

Бөөний болон жижиглэн худалдааны салбар

Уг салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.6 пунктийг хангасан байна.

Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт (оны үнээр) 2019 оны эхний улиралд 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (27.1%) их наяд төгрөгөөр өслөө.

Импортын хэмжээ 2019 оны эхний улиралд 1.3 тэрбум америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.2 (13.7%) тэрбум америк доллараар нэмэгдсэн байна. Үүнд эрдэс бүтээгдэхүүний импорт 36.6 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 29.2 сая америк доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 30.0 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 87.9 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 11. Дотоод, гадаад худалдааны борлуулалтын хэмжээ

	Дотоод худалдааны борлуулалт					Импорт, сая америк доллар				
	2017	2018	2019*	<u>2018</u> 2017	<u>2019*</u> 2018	2017	2018	2019*	<u>2018</u> 2017	<u>2019*</u> 2018
	тэрбум төгрөг			хувь		сая америк доллар			хувь	
I-III	2 802.2	3 815.5	4 851.4	136.2	127.1	776.2	1 130.5	1 285.7	145.6	113.7
I-VI	6 495.1	8 760.5		134.9		1 924.5	2 759.1		143.4	
I-IX	10 273.3	14 709.7		143.2		3 124.7	4 351.1		139.2	
I-XII	15 697.0	20 958.5		133.5		4 337.3	5 875.0		135.5	

Зураг 5. Дотоод, гадаад худалдааны борлуулалтын хэмжээ




Тээврийн салбар

Тээврийн салбарын нийт орлого (оны үнээр) 2019 оны улиралд 399.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 53.2 (15.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 6. Тээврийн салбарын орлого, тэрбум төгрөгөөр

Авто тээврийн орлого 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 26.6 (21.3%) тэрбум төгрөг, төмөр замын тээврийнх 21.9 (15.7%) тэрбум төгрөг, агаарын тээврийнх 4.8 (5.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Бүх төрлийн тээврээр 2019 оны эхний улиралд 16.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 (14.5%) сая тонноор өссөн байна. Авто тээвэр 2019 оны эхний улиралд 9.4 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (19.7%) сая тонноор өссөн байна.

Хүснэгт 12. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III	<u>2017 I-III</u> 2016 I-III	<u>2018 I-III</u> 2017 I-III	<u>2019* I-III</u> 2018 I-III
	Шилжүүлсэн сая тонн км				хувь		
Бүх төрлийн тээвэр	3 501.5	4 546.2	5 463.7	5 925.5	129.8	120.2	108.5
Авто тээвэр	660.1	1 722.5	1 640.1	1 650.9	261.0	95.2	100.7
Төмөр замын тээвэр	2 819.5	2 800.6	3 792.5	4 241.3	99.3	135.4	111.8
Агаарын тээвэр	21.9	23.1	31.1	33.3	105.6	134.4	107.1
Тээсэн ачаа, мянган тонн				хувь			
Бүх төрлийн тээвэр	7 006.7	12 310.0	14 002.6	16 034.9	175.7	113.7	114.5
Авто тээвэр	2 605.0	7 507.0	7 854.5	9 399.9	288.2	104.6	119.7
Төмөр замын тээвэр	4 401.1	4 802.4	6 147.4	6 634.3	109.1	128.0	107.9
Агаарын тээвэр	0.6	0.6	0.7	0.7	99.2	116.1	97.8

Мэдээлэл, холбооны салбар

Мэдээлэл, холбооны салбарын нийт орлого (оны үнээр) 2019 оны эхний улиралд 264.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 44.9 (20.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 13. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III	<u>2017 I-III</u> 2016 I-III	<u>2018 I-III</u> 2017 I-III	<u>2019* I-III</u> 2018 I-III
					хувь		
Нийт орлого, оны үнээр, тэрбум төг	175.2	190.5	219.2	264.1	108.7	115.1	120.5
Хүн амаас орсон орлого, тэрбум төг	125.6	131.2	141.8	180.7	104.4	108.1	127.5
Суурин утасны цэгийн тоо, мян.ш	251.5	275.2	306.1	331.3	109.4	111.2	108.2
Үүрэн утас хэрэглэгчид, мян.хүн (давхардсан тоогоор)	2 994.4	3 558.1	3 628.8	4 402.6	118.8	102.0	121.3
Утасгүй холбооны тоо	594	479	565	543	80.6	118.0	96.1
Кабелийн телевиз хэрэглэгчид, мян.хүн	699.7	780.6	843.4	756.9	111.6	108.0	89.8

Үйлчилгээний бусад салбар

Үйлчилгээний бусад салбар нь зочид буудал, нийтийн хоол; санхүү, даатгал; үл хөдлөх хөрөнгө; мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам; үйлчилгээний бусад үйл ажиллагаа зэрэг салбарыг хамарна.

Үйлчилгээний бусад салбарын нийт нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 1.8 пунктийг бүрдүүлжээ.

➤ Зочид буудал, нийтийн хоолны үйл ажиллагаа

Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого (оны үнээр) 2019 оны эхний улиралд 154.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34.4 (28.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд рестораны орлого 23.4 (52.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 14. Зочид буудал, нийтийн хоолны салбарын орлого, оны үнээр

	2016	2017	2018	2019*	<u>2017</u>	<u>2018</u>	<u>2019*</u>
	тэрбум төгрөг				хувь		
	2016	2017	2018	2019*	2016	2017	2018
I-III	65.2	88.0	119.9	154.4	134.9	136.4	128.7
IV-VI	101.3	113.3	149.4		111.9	131.8	
VII-IX	118.3	146.8	167.2		124.1	113.9	
IX-XII	82.3	113.4	157.1		137.8	138.5	
I-XII	367.1	461.5	593.6		125.7	128.6	

➤ Санхүү, даатгалын салбар

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар сарын эцэст 17.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.3 (23.5%) их наяд төгрөгөөр өсжээ. Нийт хадгаламжийн хэмжээ 2019 оны 3 дугаар сарын эцэст 13.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (22.6%) их наяд төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 15. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, хугацааны эцэст

Үзүүлэлт	2016 III	2017 III	2018 III	2019* III	<u>2017 III</u>	<u>2018 III</u>	<u>2019* III</u>
	тэрбум төгрөг				хувь		
	2016 III	2017 III	2018 III	2019* III	2016 III	2017 III	2018 III
Зээлийн өрийн үлдэгдэл	11 835.5	12 678.5	14 139.5	17 461.9	107.1	111.5	123.5
Хугацаа хэтэрсэн зээл	965.1	995.1	935.9	913.7	103.1	94.1	97.6
Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх %	8.2	7.8	6.6	5.2	-	-	-
Чанаргүй зээл	967.9	1 035.5	1 231.8	1 865.2	107.0	119.0	151.4
Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх %	8.2	8.2	8.7	10.7	-	-	-
Хадгаламж	7 571.0	8 811.6	11 372.6	13 941.5	116.4	129.1	122.6
Төгрөгийн	5 467.3	6 464.3	8 859.4	11 044.7	118.2	137.1	124.7
Гадаад валютын	2 103.6	2 347.4	2 513.2	2 896.8	111.6	107.1	115.3

➤ Төрийн удирдлага, батлан хамгаалах салбар, төсөвт байгууллага

Үйлчилгээний бусад салбарт мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; боловсрол; эрүүл мэнд, нийгмийн халамж; урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбарыг оруулах бөгөөд нэмэгдэл өртгийн дийлэнх хувь нь төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг байдаг. Зах зээлийн бус үйл ажиллагаа буюу төсөвт байгууллагын нэмэгдэл өртөг нь ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого болон байгууллагын үндсэн хөрөнгийн хэрэглээнээс бүрдэнэ. Төсөвт байгууллагын ажиллагчдын нийт цалин хөлс 2019 оны эхний улиралд 0.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 16. Төсөвт байгууллагын ажиллагчдын нийт цалин хөлс

Орлогын төрөл	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019 I-III	<u>2017 I-III</u> 2016 I-III	<u>2018 I-III</u> 2017 I-III	<u>2019 I-III</u> 2018 I-III
	тэрбум төгрөг				хувь		
Ажиллагчдын цалин хөлс	450.5	466.2	477.5	585.5	103.5	102.4	122.6
Цалин, хөлс, түүнтэй адилтгах орлого	412.9	428.2	435.6	531.5	103.7	101.7	122.0
Нийгмийн даатгалын шимтгэл	37.6	38.0	41.9	53.9	101.1	110.3	128.8


➤ Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний татвараас татаасыг хассан дүн буюу бүтээгдэхүүний цэвэр татвар нь үнэлгээний үзүүлэлт бөгөөд үндсэн үнээрх ДНБ, бүтээгдэхүүний цэвэр татварын нийлбэрээр зах зээлийн үнээрх /худалдан авагчийн үнээрх/ ДНБ-ийг тооцно. Бүтээгдэхүүний татварын гүйцэтгэл нь бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг. Бүтээгдэхүүний татварт нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний тусгай зориулалтын орлого, гадаад худалдааны татварыг оруулна. Харин бүтээгдэхүүний татааст эрчим хүчний татаас, нийтийн тээврийн татаас, улаанбуудай, махны татаас орно.

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны эхний улиралд 0.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өсөж, ДНБ-ий өсөлтийн 0.8 пунктийг бүрдүүлжээ.

Онцгой албан татвар (оны үнээр) 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 29.7 хувь, гадаад худалдааны татвар (оны үнээр) 23.8 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 0.2 хувь, үүнээс дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 10.5 хувь, импортын барааны НӨАТ 26.7 хувь, НӨАТ-ын буцаан олголт 2.1 дахин тус тус өсжээ.

Зураг 7. Бүтээгдэхүүний татвар, төрлөөр, тэрбум төгрөгөөр



Хоёр. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ

2.1 ДНБ, оны үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2019 оны эхний улиралд 7.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 (15.6%) их наяд төгрөгөөр өслөө.

Хүснэгт 17. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, оны үнээр


Бүрэлдэхүүн	2016 ¹ I-III	2017 ² I-III	2018* I-III	2019* I-III	2018* I-III 2017 ² I-III	2019* I-III 2018* I-III
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	4 748.6	5 527.8	6 426.2	7 425.8	116.3	115.6
Эцсийн хэрэглээ	3 823.0	3 881.9	4 412.7	4 891.4	113.7	110.8
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	3 047.0	3 141.8	3 596.0	3 932.6	114.5	109.4
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	776.0	740.1	816.7	958.8	110.4	117.4
Хөрөнгийн нийт хуримтлал	760.6	1 502.7	2 223.2	2 921.3	147.9	131.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	663.9	927.9	1 491.1	2 097.8	160.7	140.7
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	96.6	574.9	732.1	823.5	127.4	112.5
Цэвэр экспорт	165.0	143.1	- 209.7	- 386.9	-	-
Экспорт	2 155.9	3 418.0	3 806.5	5 015.2	111.4	131.8
Импорт	1 990.9	3 274.9	4 016.2	5 402.0	122.6	134.5

1. Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.
2. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ, оны үнээр, 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсөхөд хөрөнгийн нийт хуримтлал 0.7 (31.4%) их наяд төгрөг, бараа, үйлчилгээний экспорт 1.2 (31.8%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Хөрөнгийн нийт хуримтлалын энэхүү өсөлтөд орон сууцны бус барилга, байгууламж 57.1 хувь, машин тоног төхөөрөмж 52.1 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

ДНБ-д 2019 оны эхний улиралд эцсийн хэрэглээ 65.9 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 39.3 хувь, цэвэр экспорт (-5.2) хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс хөрөнгийн нийт хуримтлал 4.7 пунктээр өсөж, харин эцсийн хэрэглээ 2.8 пункт, цэвэр экспорт (экспорт 8.3 пункт, импорт 10.2 пунктээр нэмэгдсэн) 1.9 пунктээр буурчээ.

Зураг 8. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар



2.2 ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон, ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны эхний улиралд 3.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3 (8.6%) их наяд төгрөгөөр өслөө.

Эцсийн хэрэглээний бүрэлдэхүүн болох өрхийн хэрэглээ 2019 оны эхний улиралд нэмэгдэж, бодит дүнгээр 4.1 хувиар, төрийн байгууллагын хэрэглээ 2.5 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 18. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Бүрэлдэхүүн	2016 ¹ I-III	2017 ² I-III	2018* I-III	2019* I-III	2018* I-III 2017 ² I-III	2019* I-III 2018* I-III
	тэрбум төгрөг				хувь	
ДНБ	3 075.7	3 141.1	3 338.7	3 624.4	106.3	108.6
Эцсийн хэрэглээ	2 579.6	2 548.4	2 735.7	2 838.9	107.3	103.8
Өрхийн аж ахуй, ӨУАББ-ын эцсийн хэрэглээний зардал ²	2 058.1	2 042.8	2 201.6	2 291.7	107.8	104.1
Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	521.5	505.6	534.0	547.2	105.6	102.5
Хөрөнгийн нийт хуримтлал	481.0	1 021.4	1 369.6	1 773.1	134.1	129.5
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	415.5	634.6	935.6	1 328.7	147.4	142.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	65.4	386.8	433.9	444.4	112.2	102.4
Цэвэр экспорт	15.1	- 428.7	- 766.6	- 987.5	178.8	128.8
Экспорт	2 003.4	2 728.3	3 232.6	4 073.1	118.5	126.0
Импорт	1 988.3	3 157.0	3 999.1	5 060.6	126.7	126.5

1. Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.
2. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлалыг оруулсан.

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 8.6 хувиар өсөхөд хөрөнгийн нийт хуримтлал 0.4 (29.5%) их наяд төгрөг, бараа, үйлчилгээний экспорт 0.8 (26.0%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бөгөөд уг өсөлтийн 3.1 пунктийг эцсийн хэрэглээ, 12.1 пунктийг хөрөнгийн нийт хуримтлал, (-6.6) пунктийг цэвэр экспорт бүрдүүлжээ.

Зураг 9. ДНБ-ий өсөлтөд бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоо



Хүснэгт 19. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2019* I-III	<u>2019* I-III</u> <u>2018* I-III</u>
	тэрбум төгрөг				хувь
ДНБ, оны үнээр	4 738.1	5 831.5	6 783.8	7 936.7	117.0
ДНБ, 2010 оны үнээр	2 934.3	3 058.4	3 247.7	3 527.6	108.6
ДНБ-ий бодит өсөлт, бүүралт, % (өмнөх оны мөн үеийнхээс)	2.9	4.2	6.2	8.6	-
Уул уурхайн	15.6	- 5.4	3.0	14.4	-
Уул уурхайн бус	- 1.3	7.9	7.3	6.7	-
ХҮИ, өмнөх оны мөн үеэс,%	1.7	2.5	6.6	6.7	-
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	1 095.2	1 504.2	1 810.9	2 163.4	119.5
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл	1 710.9	1 759.2	1 836.6	1 969.1	107.2
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	- 615.7	- 255.1	- 25.8	194.3	- 753.9
Мөнгө M1, хугацааны эцэст	1 583.7	2 124.9	2 776.7	3 764.9	135.6
Мөнгө M2, хугацааны эцэст	10 112.4	12 259.3	16 073.9	19 694.8	122.5
Зээлийн өрийн үлдэгдэл, хугацааны эцэст	11 835.5	12 678.5	14 139.5	17 461.9	123.5
Хадгаламжийн нийт хэмжээ, хугацааны эцэст	7 571.0	8 811.6	11 372.6	13 941.5	122.6
АҮ-ийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл	1 805.9	2 688.9	3 267.6	3 839.9	117.5
Уул уурхай	1 200.5	1 962.2	2 334.6	2 832.9	121.3
Уул уурхайн бус	605.4	726.7	933.1	1 007.0	107.9
Барилга угсралт, их засварын ажил	229.4	233.2	335.9	391.1	116.4
Худалдааны борлуулалт	2 143.6	2 802.2	3 815.5	4 851.4	127.1
Мэдээлэл холбооны орлого	175.2	190.5	219.2	264.1	120.5
Тээврийн нийт орлого	225.2	291.8	346.6	399.8	115.3
Шилжүүлсэн сая тонн км	3 501.5	4 546.2	5 463.7	5 925.5	108.5
Авто тээвэр	660.1	1 722.5	1 640.1	1 650.9	100.7
Төмөр замын тээвэр	2 819.5	2 800.6	3 792.5	4 241.3	111.8
Агаарын тээвэр	21.9	23.1	31.1	33.3	107.1
Тээсэн ачаа, мянган тонн	7 006.7	12 310.0	14 002.6	16 034.9	114.5
Авто тээвэр	2 605.0	7 507.0	7 854.5	9 399.9	119.7
Төмөр замын тээвэр	4 401.1	4 802.4	6 147.4	6 634.3	107.9
Агаарын тээвэр	0.6	0.6	0.7	0.7	97.8
Зочид буудал, нийтийн хоолны салбарын нийт орлого	65.2	88.0	119.9	154.4	128.7
Гадаад худалдаа, сая америк доллар					
Нийт эргэлт	1 558.0	2 076.1	2 612.9	3 057.4	117.0
Экспорт	959.0	1 299.9	1 482.4	1 771.7	119.5
Импорт	599.1	776.2	1 130.5	1 285.7	113.7
Тэнцэл	359.9	523.7	351.9	486.0	138.1
Бүтээгдэхүүний татвар					
НӨАТ	227.7	301.4	380.9	381.6	100.2
Онцгой татвар	128.9	100.0	164.6	213.5	129.7
Гадаад худалдааны татвар	54.6	86.3	124.7	154.4	123.8
Нүүрс:					
Олборлолт, мянган тонн	5 346.3	11 698.1	11 197.6	12 887.6	115.1
Экспорт, мянган тонн	3 270.7	8 137.5	6 769.0	7 804.2	115.3